

Саналын бичиг (Товч утга)

**- Хамтын нийгмийн хэв маяг ба
дунд болон урт хугацааны асуудлын тухай -**

2021 он 11-р сар

**Гадаад иргэнийг багтаасан хамтын нийгмийн биелүүлэлтийн төлөөх
мэргэжилтэнүүдийн хурал**

Гадаад иргэн болон хамтын нийгмийн төлөөх зорилт (Гурван төлөв)

“Хэнийг ч орхигдуулахгүй” буюу тогтвортой, олон талт, хүртээмжтэй нийгмийн биелүүлэлтийн төлөөх Олон улсын зорилтыг тогтоосон SDGs-ийн үзэл санаанд үндэслэсэн хамтын нийгмийн төлөө зоривол зохих гурван төлөв

Аюулгүй, тайван нийгэм

Цаашдын Япон улсын нийгмийг хамтдаа бүтээх нэгэн гишүүн болж буй гадаад иргэд болон бусад бүх хүмүүсийн хувьд аюулгүй, тайван амьдрах боломжтой нийгэм

Гадаад иргэн болон хамтын нийгмийн төлөөх зорилт (Гурван төлөв)

Олон талт, идэвхжил бүхий нийгэм

Янз бүрийн гаралтай, туршлагатай гадаад иргэд болон бусад бүх хүмүүс нийгмийн амьдралд оролцож өөрсдийн чадвар, хүчин чадлаа бүрэн гаргах боломжтой олон талт, идэвхжил бүхий нийгэм

Хувь хүний нэр төр болон хүний эрхийг хүндэтгэдэг нийгэм

Гадаад иргэн ба бусад бүх хүмүүс харилцахад бие биеэ хүндэтгэн, хүний эрхийг дээдэлж, ялгаварлал үгүй амьдрах боломжтой нийгэм

Гадаад иргэнийг багтаасан хамтын нийгмийн төлөө зоривол зохих гурван төлөвийн хэрэгжилтийн 4 гол зүйл

Хамтийн нийгмийн төлөө зоривол зохих гурван төлөвийг биелүүлэхийн тулд, дунд болон урт хугацаагаар шийдвэрлэх асуудал болгон дараах 4 гол зүйлийг сонгон авч, тус бүрийн ажлын чиглэлийг нэгтгэн тэмдэглэв.

*** Дэмжлэгийг үзүүлэхэд “Гадаад улсын хамаарал бүхий хүн”-д ч мөн анхааран арга хэмжээг бүрдүүлбэл зохино.**

1 Түвэг саадгүй харилцаа холбоо болон нийгмийн оролцооны төлөөх арга хэмжээ (Жишээ нь: Япон хэлний боловсрол гэх мэт)

2 Гадаад иргэдэд зориулсан мэдээлэл, зөвлөгөөний системийг бэхжүүлэх

3 Насны үечлэл, амьдралын мөчлөгт тааруулсан дэмжлэг

4 Хамтийн нийгмийн үндэсийг бүрдүүлэх арга хэмжээ



Засгийн газрын хувьд, үнэн зөв бодит байдлыг ойлгож, хамтын нийгмийн хэв маяг болон хамтын нийгмийг бий болгохын төлөө хэрэгжүүлэх арга хэмжээг KPI (Key Performance Indicators буюу Гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлт)-ийг тусгасан дунд болон урт хугацааны үйл ажиллагааны төлөвлөгөө болгож нэгтгэн харуулахыг гүнээ найдаж байна.

Япон улсад оршин суугаа гадаад иргэдийн нөхцөл байдлын өөрчлөлт ①

Оршин суугаа гадаад иргэдийн өнөөгийн нөхцөл байдал

Оршин суугаа гадаад иргэний тоо

2.89 сая орчим (2020 оны эцсийн байдал)
[2019 оны эцэст түүхэн рекорд түвшинд өсөв]

Япон улсын нийт хүн ам


126.23 сая (2020 оны 10-р сарын 1-ний байдал)

Япон улсын нийт хүн амд эзлэх хувь

2.29% (2020 оны байдал) [2019 он түүхэн рекорд түвшинд өсөв]

Хөдөлмөр эрхдэг гадаад иргэний тоо


1.72 сая орчим (2020 оны 10-р сарын эцсийн байдал)
[2020 оны 10-р сарын эцэст түүхэн рекорд түвшинд өсөв]




Япон улсад оршин суугаа гадаад иргэдийн нөхцөл байдлын өөрчлөлт ②

Оршин суугаа гадаад иргэний тоо ба бүрдлийн өөрчлөлт

Оршин суух зөвшөөрлийн ангиллаар




Иргэншилээр



● “Байнгын оршин суугч” нийтийн дөрөвний нэгээс илүүг эзэлж байгаа нөхцөл байдал нь хэвээрээ байгаа болоч “Ур чадварын дадлага”, “Техник технологийн мэргэжилтэн, олон улсын харилцааны ажилтан” ангилалын тоо огцом өссөн байна

● “БНСУ”, “БНСАУ” болон “Бразил” оршин суугчийн тоо буурч, “Вьетнам” оршин суугчийн тоо ихээр өссөн байна

Хүйс, нас, оршин суух зөвшөөрлийн ангиллаар: оршин суугаа гадаад иргэд



● 20-иод насныханд “Их дээд сургуулийн оюутан”, “Ур чадварын дадлага”, “Техник технологийн мэргэжилтэн, олон улсын харилцааны ажилтан” ангиллын харьцаа өндөр байна
● 40-өөс дээш болон 60-аас дээш насны эмэгтэйчүүдийн 60-аас илүү хувь нь “Байнгын оршин суугч” статустай байна

Түвэг саадгүй харилцаа холбоо болон нийгмийн оролцооны төлөөх арга хэмжээ (Жишээ нь: Япон хэлний боловсрол гэх мэт) (Гол зүйл-1)

Өнөөгийн нөхцөл байдал, асуудал

Япон хэл сурах боломж олгох

- Япон хэлний сургалт зохион байгуулагддаггүй хот, дүүрэгт оршин суудаг гадаад иргэд 580,000 орчим (2020 оны 11-р сарын байдал)
→ Япон хэлний боловсрол олж авах боломж хангалтгүй байна
- Аж амьдралын тухай танилцуулга зохион байгуулагдаж байгаа эсэх. (Агуулга нь өөр өөр байна)(Оршин суух хот, дүүргийн захиргааны тусгай арга хэмжээ авч байгаа эсэх, агуулга нь өөр өөр байна)
→ Япон улсын ёс заншил, нийгмийн тогтолцооны тухай ойлголтонд ялгаа үүсч болох нөхцөл байдал

Насны үечлэлд тааруулсан тогтолцоотой Япон хэлний сургалт

- Гадаад иргэд насны үечлэлд тааруулан эзэмших шаардлагатай Япон хэлний түвшинд стандарт тогтоогоогүй байна
→ Гадаад иргэд өөрсдийн шаардлага болон түвшинд тааруулж системтэйгээр Япон хэлний мэдлэгээ дээшлүүлэх нь бэрхшээлтэй байна

Япон хэлний сургалтын чанарыг дээшлүүлэх

- Япон хэлний багш нарын заах чадвар болон сургалтын чанар нь харилцан адилгүй байна
- Япон хэлний багш нарын хөдөлмөрийн нөхцөл нь хангалттай биш, мөн урт хугацааны ажлын туршлага бий болгох зэрэг нь бэрхшээлтэй байна
→ Япон хэлний багш нарын тоог хүртээмжтэй болгох, мөн заах чадвар болон чанар дээшлүүлэх шаардлагатай байна

Гол арга хэмжээний чиг хандлага

Ахуй амьдралд хэрэгцээтэй Япон хэл болон Япон улсын ёс заншил, нийгмийн тогтолцооны тухай мэдлэгийг эзэмших орчныг бүрдүүлэх

<Гадаад иргэд ахуй амьдралдаа хэрэгцээтэй Япон хэл эзэмших орчныг бүрдүүлэх>

- Ахуй амьдралд шаардлагатай түвшний Япон хэлийг эзэмших зорилго бүхий Япон хэлний боловсрол болон нийгмийн амьдралд түвэг саадгүй дасахын төлөөх аж амьдралын сургалтад хамрагдах боломж олгох
- Оршин суух зөвшөөрлийн материал бүрдүүлэх зэрэг янз бүрийн тохиолдолд ашиглаж, суралцаж болох мэдлэг, мэдээллээр хангах
- Хилээр шалган нэвтрэх, оршин суух хяналтын газар гэх мэт байгууллагууд нь хамтран ажиллаж, сургалтын хөтөлбөр, сургалтын материалыг зохиох болон онлайн сургалт зэргийг зохион байгуулах талаар судлан нягтлах

<Насны үечлэлд тааруулан, системтэйгээр Япон хэлийг сурах орчныг бүрдүүлэх>

- Гадаад иргэд сурлцах шаардлага болон түвшиндээ таарсан Япон хэлний боловсролын байгууллагыг сонгохдоо Япон хэлний чадварын үнэлгээний стандарт (Япон хэлний боловсролын лавлагааны хүрээ)-г ашиглан, төрөл бүрийн байгууллагын боловсролын жишгийг тодорхой харах боломжийг бүрдүүлэх

<Япон хэлний сургалтын чанарыг дээшлүүлэх, мэргэжлийн хүний нөөцөөр хангах арга хэмжээг идэвхижүүлэх>

- “Мэргэшсэн Япон хэлний багш”(Албан бус нэр) эрхийн үнэмлэх бий болгох, Япон хэлний багш нарын урт хугацааны ажлын туршлага бий болгох боломж бүхий төлөвлөгөө бүрдүүлэх

Гадаад иргэдэд зориулсан мэдээлэл, зөвлөгөөний системийг бэхжүүлэх (Гол зүйл-2)

Өнөөгийн нөхцөл байдал, асуудал

Гадаад иргэдийг мэдээллээр хангах

- Холбогдох яам, газруудын хэрэгжих арга хэмжээний (Шинэ коронавируст халдварын цар тахлын нөлөөд автаж буй Япон улсад оршин суугаа гадаад иргэдэд үзүүлэх дэмжлэг багтана.) тухай мэдээлэл цацагдаж байгаа боловч, гадаад иргэн өөрийнхөө нөхцөл байдалд тааруулан мэдээллийг оновчтой, шуурхай сонгох нь бэрхшээлтэй байна
- Төрөл бүрийн дэмжлэгийн тухай мэдээллийг түгээх арга, гадаад иргэдийн мэдээлэл авч буй мэдээллийн хэрэгсэл нь таарахгүй байх гэх мэт шалтгааны улмаас хэрэгтэй мэдээлэл нь хүргэгдээгүй байна

→Гадаад иргэдэд хэрэгтэй дэмжлэгийг шуурхай, баттай олгогдох байдлаар мэдээлэл нь цацагдахгүй байна

Гадаад иргэдэд зориулсан зөвлөгөөний систем

- Гадаад иргэний тоо нэмэгдэж, өөр өөр иргэншилтэй хүмүүс оршин суух болсноор харилцаа холбоо, орчуулгын асуудалд бэрхшээл үүсээд байна
- Гадаад иргэнийг хүлээн авах орчныг бүрдүүлэх мөнгөн тусламж нь бүс нутгийн бодит байдалд нийцэхгүй байна
- Гадаад иргэдэд тулгарах асуудлууд нь маш олон талтай, нарийн түвэгтэй бөгөөд, холбогдох байгууллагуудын нягт хамтран ажиллагаа нь улам ихээр шаардагдаад байна
- Орон нутгийн засаг захиргааны ажилтан нь Япон хэлний чадвар хангалтгүй гадаад иргэдтэй харьцахад бэрхшээл үүсч байна

→Гадаад иргэдэд хэрэгтэй дэмжлэгийн хүрээнд шуурхай, баталгаатай зөвлөгөөний систем хангагдаагүй байна

Гол арга хэмжээний чиг хандлага

Гадаад иргэдэд хэрэгтэй дэмжлэгийн хүрээнд шуурхай, баттай мэдээлэл олгохын тулд мэдээлэл түгээх болон зөвлөгөөний системийг бэхжүүлсэн орчныг бүрдүүлэх

<Гадаад иргэдэд шаардлагатай мэдээллийг хүргэх>

- Мэдээллийн агууллагыг боловсруулах (Юу мэдээлэх вэ)
 - Хангар мэдээллийн стандарт гэх мэтийг тогтоосон удирдамжийг боловсруулах
- Мэдээллийг түгээх арга (Яаж мэдээлэх вэ)
 - Бичгэн мэдээллээс гадна зураглалаар ойлгуулах аргыг боловсруулах
- Мэдээллийн хэрэгслийг зөв сонгох
 - "Myportal" цахим хуудсыг ашиглан хувийн, шуурхай мэдэгдэл маягаар мэдээллийг цацах

<Гадаад иргэдэд тулгарч буй асуудалд таарсан зөвлөгөөний системийг бэхжүүлэх>

- Нэгдсэн зөвлөгөөний цонх үйлчилгээний дэмжлэгийг бэхжүүлэх
 - Гадаад иргэнийг хүлээн авах орчныг бүрдүүлэх мөнгөн тусламж олгох нөхцөлийг өөрчлөн засах талаар хэрэлцэх, нэгдсэн зөвлөгөөний үйлчилгээг эрчимжүүлэх гэх мэт
- Бүс нутгийн холбогдох байгууллагуудын хамтын ажиллагаа болон гадаад иргэдийг дэмжигч нийгэмлэгийг эрчимжүүлэх
 - FRESC-тэй адил байгууллагууд хоорондоо хамтран ажиллаж зөвлөгөөний үйлчилгээг үзүүлэх гэх мэт
 - Хувийн дэмжлэгийн байгууллагаар дамжуулан төрийн дэмжлэгийн тухай мэдээллийг олгох, гадаад иргэнд тулгарч буй асуудлуудыг шуурхай, оновчтой ойлгож шийдвэрлэх механизм бий болгох

Насны үечлэл, амьдралын мөчлөгт тааруулсан дэмжлэг (Гол зүйл-3)

Өнөөгийн нөхцөл байдал, асуудал


Насны үечлэлд таарсан дэмжлэг

Насны үечлэл бүрээр Япон улсын нийгмийн амьдралд оролцох боломжоор хангах дэмжлэг

Амьдралын мөчлөгт таарсан дэмжлэг

Насны үечлэлийн шилжилтэд тохирсон хэрэгцээ бүхий дэмжлэг (Шилжилтэд дэмжлэг үзүүлэх)

- Сургуульд элсэх, ажилд орох гэх мэтийн насны үечлэлд тохиох шилжилтэд асуудал тулгарч байна
(Үүсэж буй асуудлын жишээ)
 - Нийт ахлах сургуулийн сурагч (Тусгай дэмжлэгийн сургуулийн ахлах анги багтахгүй)-ийн 1.3% нь сургуулиас гарч байгаа бөгөөд, Япон хэлний боловсрол олгох шаардлагатай ахлах сургуулийн сурагч (Тусгай дэмжлэгийн сургуулийн ахлах анги багтахгүй)-ийн 9.6% нь сургуулиас гарч байна
- Ялангуяа насны үечлэл тус бүр дээр дэмжлэг хэрэгтэй
 - Тус бүрийн насны үечлэл дээр гадаад иргэнд тулгарах бодит байдал болон асуудлыг ойлгоогүй байна
 - “Шилжилт” дээрх дэмжлэгийн хэрэгжилт чухалд тавигдаж байна



Гол арга хэмжээний чиг хандлага

Бодит байдлыг ойлгон, тус бүрийн насны үечлэл болон амьдралын мөчлөгт таарсан нягт нарийн дэмжлэг үзүүлэх

<<“Хөхүүл хүүхэд”, “Сургуулийн нас” болон “Залуу, идэр нас”-ны эхний үеийн гадаад иргэдэд зориулсан дэмжлэг (Жирэмсэн эхчүүд, амаржилт, хүүхэд өсгөх, сургуульд элсэх, сургуульд дэвшин суралцах г.м)>

- Гадаад иргэний гэр бүлийг нийгмээс тусгаарлагдмал болгохгүйн төлөө дэмжлэг үзүүлэх зорилгоор бодит байдлын судалгаа хийх, хэрэгцээ шаардлагыг тодорхой болгох, хүүхэд өсгөхөд таатай орчныг бүрдүүлэх гэх мэт
- Гадаад иргэдийн хүүхэд сургуульд элсэхэд шаардагдах элсэлтийн нөхцөл байдлыг тодорхойлох (нэгдмэл хяналт), Preschool байгуулахад дэмжлэг үзүүлэх гэх мэт
- Сурах сонирхол татах сургалтын загвар танилцуулах гэх мэт гадаад иргэний хүүхдүүдэд зориулсан карьер бүтээх ерөнхий дэмжлэг (Ахлах сургуулийн элсэлтийн шалгалтад тусгай квот тогтоох, шалгалт авахад тусгайлан анхаарах)

<<“Залуу, идэр нас”-ны үеийн гадаад иргэдэд зориулсан дэмжлэг (Хөдөлмөр эрхлэхэд дэмжих)>

- Гадаад иргэнтэй харилцаа холбоо үүсгэхэд зориулсан хялбаршуулсан Япон хэлний үг хэллэгийг ашиглаж, харилцан ойлголцох боломжтой орчныг бүрдүүлэх
- Хүлээн авагч компаний тодорхой хэмжээний зардлаар ажилчдад хөдөлмөр эрхлэлтийн тогтвортой байдал болон ажлын туршлагыг бэхжүүлэхэд дэмжих зорилготой сургалт, ажил мэргэжлийн дадлагажилтад хамрагдах боломж олгох

<<“Өндөр нас”-ны үеийн гадаад иргэдэд зориулсан дэмжлэг (Асран хамгаалалт гэх мэтээр дэмжих)>

- Гадаад иргэний тулгарч буй нөхцөл байдал болон дэмжлэгийн шаардлагыг ойлгон, бүх хүмүүс ойлгож хүлээн авах дэмжлэгийн хэв маягыг нягтлан боловсруулах

Хамтын нийгмийн үндэсийг бүрдүүлэх арга хэмжээ (Гол зүйл-4)

Өнөөгийн нөхцөл байдал, асуудал

1 Хамтын нийгмийг бүрдүүлэх уур амьсгал бий болгох

- Сургууль, ажлын байр, бүс нутаг гэх мэтийн нийгмийн янз бүрийн талбарт гадаад иргэдийг ялгаварлан гадуурхалт

2 Нийгмийн тогтолцоо зэрэг мэдлэг олгох төлөвлөгөө бүрдүүлэх

- Япон соёл, ёс заншил, татвар, нийгмийн халамж гэх мэт нийгмийн тогтолцооны тухай хангалттай мэдлэггүйгээс болж нийтийн үүрэг биелүүлэхгүй байгаа хүмүүс бий

3 Гадаад иргэний ахуй амьдралын бодит байдлыг мэдэж авах

- Япон улсын засгийн газрын статистик дээр “Иргэншил” гэх мэт ангилалтайгаар явагдаж байгаа нь цөөхөн бөгөөд гадаад иргэний ахуй амьдралын бодит байдлын тухай хангалттай мэдэж авах нь бэрхшээлтэй байна

4 Гадаад иргэдэд үзүүлэх дэмжлэг болон оршин суугчийн хяналтын мэдээлэл цуглуулах, холбогдох байгууллагууд хамтран ажиллах

- Хувийн дэмжлэгийн байгууллагуудтай хамтран ажиллаж мэдээлэл цуглуулах үйл явц хангалтгүй
- Тус бүрийн холбогдох байгууллагуудын олгох боломжтой дэмжлэгийн зохицуулагчийг бэлтгэх шаардлагатай
- Гадаад иргэдийн амьдрах таатай нөхцөлийг дээшлүүлэх, оршин суугчийн зохимжтой хяналтыг биелүүлэх зорилгоор хилийн шалган нэвтрэх, оршин суух хяналтын газарт “My Number”/Хувийн дугаар/ системтэй холбогдуулсан оршин суугчийн хяналтад шаардах мэдээллийг үр ашигтайгаар олж авах

5 Гадаад иргэдийн нийгэм дэх оролцоо

- Гадаад иргэдийн хувьд нийгмийн үйл ажиллагаанд оролцож өөрийн чадвараа бүрэн гаргахад нь туслах чиглэлийн арга хэмжээ хангалтгүй байна
- Нийгмийн харилцаанд оролцох сонирхолтой гадаад иргэдэд идэвх зүтгэл гаргах боломжийг нээлттэй болгох шаардлагатай

→Бүх хүмүүс олон талт байдлыг хүндэтгэж, мөн хувь хүний чадварыг бүрэн гаргах боломжтой, хамтын нийгмийг бий болгохын төлөөх үндэс суурь бүрдэл хангалттай бүрэлдээгүй байна

Гол арга хэмжээний чиг хандлага

Зоривол зохих хамтын нийгмийг бий болгохын төлөө ойлгоц бий болгох, нийгмийн тогтолцооны тухай мэдлэг олгох зэрэг төлөвлөгөө, суурь бүрдүүлэх

<Хамтын нийгмийн төлөөх уур амьсгал бий болгох>

- Гадаад иргэнтэй нэг нийгэмд аж төрөх хамтын нийгмийн талаар сурталчлах 1 сарын аян тогтоох гэх мэтээр сонирхол төрүүлэх болон гүнзгий ойлгуулттой болгох арга хэмжээг эрчимжүүлэх
- Бага насны хүүхдийн боловсрол, сургуулийн боловсрол гэх мэтийн хөтөлбөрт хамтын нийгмийн боловсролыг оруулах талаар судлах

<Нийгмийн тогтолцоо гэх мэт мэдлэгтэй болгохын төлөөх бүтэц бүрдүүлэх>

- Татвар төлөх, нийгмийн даатгалын төлбөр төлөх зэрэг нийтийн үүргийн тухай мэдээллийг аж амьдралын тухай танилцуулгаар дамжуулан олгож байх

<Гадаад иргэний ахуй амьдралын нөхцөл байдлын судалгааны тухай засгийн газрын статистикийг сайжруулах гэх мэт>

- Япон улсын засгийн газрын статистикийг сайжруулах гэх мэтээр гадаад иргэний ахуй амьдралын бодит байдлыг мэдэж авах, тус бодит байдлыг үндэслэн арга хэмжээ санаачлах, KPI-г үндэслэн арга хэмжээний хэрэгжилтийг хянан хангах

<Хамтын нийгмийн суурь бүрдүүлэхийн төлөө мэдээлэл цуглуулах, холбогдох байгууллагууд хамтран ажиллах>

- Хувийн дэмжлэгийн байгууллагууд болон дэмжлэгийн зохицуулагчид мэдээлэл олгох, эдийн засгийн дэмжлэгийг багтаасан арга хэмжээг судалж үзэх
- Ерөнхий дэмжлэгийн зохицуулагчийг бэлтгэх, албан ёсоор батлах тогтолцооны тухай судлах